БАТЛАВ:

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ..... Л.ТӨМӨРЧӨДӨР

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ, СУУРЬШЛЫН БҮСҮҮДИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР

Дугаар-04/25

2025 оны 05 сарын 30-ны өдөр Зуунмод сум

1	Ерөнхий төлөвлөгөө боловсруулах үндэслэл	- Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.1, 8.1.2, 9.1.4, 15.1.2 дэх заалт; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 3.6.1; - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээ 1.4.1.8; - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 сарын 13 -ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэл; - Төв аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05 ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан Сэргэлэн сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө; - Сэргэлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2025 оны төсөв батлах тухай” 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 01 дүгээр тогтоол; **Зорилго:** Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн хөгжлийн баримт бичигт үндэслэн Төв аймгийн Сэргэлэн сумын төв болон тухайн сумын нутаг дэвсгэрт дэх суурьшлын бүсүүдийг хөгжүүлэх хот төлөвлөлтийн зураг төслийг боловсруулна. Сумын төв, суурьшлын бүсийн хөгжлийн үзэл баримтлал, орон зайн төлөвлөлтийг орчин үеийн “тогтвортой”, “ухаалаг”, “ногоон” зарчимд нийцүүлэн тодорхойлж гүйцэтгэнэ.
2	Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал	**Байршил:** Төв аймгийн Сэргэлэн сум нь Улаанбаатар хот болон Төв аймгийн Алтанбулаг, Эрдэнэ, Баян, Баянцагаан сумтай хиллэн орших бөгөөд 386574.0 га нутаг дэвсгэртэй. Баянбүрд, Хайрхан, Хөшиг, Эрдэнэ-Уул, Авдар гэсэн 4 багтай. Сэргэлэн сумын төв нь Улаанбаатар хотоос 62 км. Төв аймгийн төвөөс 18 км-ийн зайд оршдог. Сэргэлэн сум нь Уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуй болон үндэсний хэмжээний бүтээн байгуулалт болох Чингис хаан олон улсын нисэх буудал, Хүннү хот, Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс үйл ажиллагаа явуулж байна. **Хүн ам:** Төв аймгийн Сэргэлэн сум нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 785 өрхийн 2049 хүн амтай. Тус суманд сургуулийн өмнөх боловсролд 98 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 320 сурагч суралцаж байна. **Байгаль орчин:** Сэргэлэн сумын нутаг дэвсгэр нь далайн түвшнээс дээш 1200-1500 метр өргөгдсөн Хангай, Хэнтийн